



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠤᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/203

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 22 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ сэргэлтийн бодлогын аж үйлдвэржилтийн сэргэлт, "Алтайн малчдын түншлэл" төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумдын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдийн Улаанбаатар хотод туршлага судлахад замын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах 3,500,000 (гурван сая таван зуун мянга) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР